



СҮХБААТАР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 13-өдөр

Дугаар 5

Баруун-Урт

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Хадлан бэлтгэх, ашиглах үйл ажиллагаанд мөрдөх хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмж гарган мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /З.Энхтөр/-д даалгасугай.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн байгаль орчны хороонд үүрэг болгосугай.
4. Уг захирамж гарсантай холбогдуулж иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханггуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /С.Сарантуяа/, Цагдаагийн газар /Т.Ганзориг/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Э.Өлзийтогтох/, Ус цаг уур, орчны шинжилгээний газар /Х.Энхбаяр/, Байгаль орчин аялал жуулчлалын газар/ Д.Гансүх/, Онцгой байдлын газар / Т. Энхбаатар/ , сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.



D:/My Documents /A-4 doc

0100 102



## Хадлан бэлтгэх, ашиглах үйл ажиллагаанд мөрдөх, хяналт тавих журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Газрын тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгалийн ургамлын тухай хууль”, “Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хууль”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль”, “Газрын төлбөрийн тухай хууль”, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол, Өвс, техникийн ерөнхий шаардлага MNS 0592:2008, Өвс тээвэрлэлтийн ерөнхий шаардлага MNS 5647:2006, аймгийн ИТХ-ын 2016 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэл болгон хадлангийн зориулалтаар олгох газрын эзэмшил, ашиглалт, хамгаалалт, хяналт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулах, иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг баримтлан чанд мөрдөж ажиллана.

### Хоёр. Хадлангийн талбайн хуваарилалт, хадлан бэлтгэх хугацаа, гэрээ байгуулах талаар

2.1. Тухайн жилд хадлан бэлтгэх талбайн байршил, түүнийг хуваарилах хэмжээг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулж аймгийн Засаг даргын захирамжаар томилно.

2.2. Хадлан бэлтгэх талбайг багийн ИНХ-ын саналыг үндэслэн, сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу олгох ба улсын болон орон нутгийн отрын бүс нутаг болгож тогтоосон газар хадлан бэлтгүүлэхгүй байх бодлогыг барьж ажиллана.

2.3. Улсын тусгай хамгаалалттай газар болон Улсын тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд хадлан бэлтгэх үйл ажиллагааны зөвшөөрөл олгохгүй байх.

2.4. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь хадлан бэлтгэх хүсэлтийг 7 дугаар сарын 15-ны дотор сумын Засаг даргын Тамгын газарт бичгээр гаргана. Хүсэлт ирүүлэхдээ дараах баримт бичгийн бүрдлийг хангасан байна. Үүнд:

- а/ хадлангийн талбайн газрын хэмжилтийг хийлгэсэн тухайн сумын газрын даамлын дүгнэлт
- б/ хадлан бэлтгэж дууссаны дараа талбайг нөхөн сэргээх төсөл
- в/ Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн дүгнэлт

г/ Байгаль орчин, аялал жуулчлалын газраас байгаль орчинд нөлөөлөх байдлын өрөнхий үнэлгээний дүгнэлт

д/ Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт

е/ 1 га тутмаас авах ургацын хэмжээг тодорхойлсон дүгнэлт

2.5. Тухайн сумын Засаг даргын Тамгын газар нь тус журмын 2.2, 2.4-т заасан баримт бичгийг үндэслэн ахуйн хэрэгцээний зориулалтаар ашиглах хадлангийн газар олгох асуудлыг шийдвэрлэнэ.

2.6. Хадлангийн талбайг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглуулах гэрээг ажлын хэсгийн болон дээрх мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн аймаг, сумын Засаг дарга, иргэн, аж ахуйн нэгжтэй гуравласан гэрээ байгуулна. Хадлан бэлтгэх талбай ашиглуулах гэрээний загварыг уг журмын хавсралтаар батлана.

2.7. Хадлангийн талбайн газрын төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөрийг төлж, хэмжилт хийж тогтоолгосны дараа хадлан бэлтгэх иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулна.

2.8. Хадлан бэлтгэх хугацаа: Тухайн оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тухайн оны 10 дугаар сарын 01-ийг хүртэл байна.

2.9. Орон нутгийн болон бусад аймаг, сумдын малчдын бүлэг, иргэн, аж ахуйн нэгжээс улс, аймаг, сумын аюулгүйн нөөцөд өвс бэлтгэх хүсэлт ирүүлсэн тохиолдолд нэн түрүүнд шийдвэрлэж талбайг хуваарилж өгнө.

2.10. Хадлангийн талбайг олгоходо газар дээр нь тухайн сумын газрын даамал хэмжилт хийж тэмдэгжүүлнэ. Маргаан гарвал магадлан хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

2.11. Хадлан бэлтгэх талбайн 1 га тутмаас авах ургацын хэмжээг Ус, цаг уур, орчны шинжилгээний газар жил бүр тогтооно.

### **Гурав. Хадлан бэлтгэж буй иргэн, аж ахуйн нэгжээс авах төлбөр, хураамж**

3.1. Үйлдвэрлэлийн зориулалтаар хадлан бэлтгэж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс байгалийн ургамал ашигласны төлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 03 дугаар тогтоолын хавсралтанд заагдсан "Элбэг ургамал" гэсэн ангиллын дагуу 1 га хадлангийн талбайгаас бэлтгэх өвсний 5% -иар тооцож авна.

3.2. Хадлан бэлтгэж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс газрын төлбөрийг тухайн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 1 га-д ногдох газрын төлбөрийн хэмжээгээр тооцож авна.

3.3. Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэх бөгөөд үүнээс 40%-ийг тухайн сумын Байгаль орчныг хамгаалах санд шилжүүлэн, зарцуулалтыг жил бүр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд холбогдох албан тушаалтан тайлагнана.

**Дөрөв. Хадлан бэлтгэл, ашиглалтын талаархи төрийн  
байгууллагын бүрэн эрх**

**4.1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэн эрх:**

- 4.1.1. Хадлан бэлтгэх талбайн хэмжээг аймгийн Засаг даргын саналыг үндэслэн жил бүр тогтооно;
- 4.1.2. Хадлан бэлтгэх үйл ажиллагаатай холбогдон гаргасан шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих;
- 4.1.3. Улс, аймаг, сумын аюулгүйн нөөц, ахуйн хэрэгцээний зориулалтаар хадлан бэлтгэж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг байгалийн ургамал ашигласны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

**4.2 Аймгийн Засаг даргын эрх, уурэг:**

- 4.2.1. Хадлан бэлтгэх газар нутгийн хэмжээ, зааг, өвс тээвэрлэх зам маршрутыг гэрээнд тусган мөрдүүлэх;
- 4.2.2. Байгалийн ургамлын гарц, ургалтын нөөц, хадлан хадах талбайн хэмжээ, солбицолыг нарийвчлан тогтоох ажлын хэсгийг жил бүр томилох;
- 4.2.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэх иргэн, аж ахуй нэгж, байгууллагад зөвшөөрөл олгож, гэрээ байгуулах
- 4.2.4. Хадлан бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой гарсан тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах

**4.3 Сумын Засаг даргын эрх, уурэг :**

- 4.3.1. Хадлан авах бололцоотой талбайг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах тухай багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд жил бүр тусгувалж, хэрэгжилтийг хангах
- 4.3.2. Улс, аймаг, сумын аюулгүйн нөөц, ахуйн хэрэгцээний зориулалтаар хадлан бэлтгэж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хадлангийн талбайн зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, хяналт тавих асуудлыг шийдвэрлэх
- 4.3.3. Хадлан бэлтгэх газар нутгийн хэмжээ, зааг, өвс тээвэрлэх зам маршрутыг гэрээнд тусган мөрдүүлэх;
- 4.3.4. Хадлан бэлтгэх, ашиглах гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийн гэрээний хэрэгжилтэнд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавьж, гэрээний биелэлтийг хангуулах
- 4.3.5. Сумын ИТХ-аас батласан талбайд хадлан бэлтгэх хугацаанд мал бэлчээхгүй байх

**Тав. Хадлан бэлтгэх иргэн, аж ахуйн нэгжид  
тавих үндсэн шаардлага**

- 5.1. Хадлан бэлтгэх үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгж, байгууллага, иргэн нь Монгол Улсад бүртгэлтэй, дотоодын аж ахуйн нэгж байгууллага болон иргэн байна.

5.2. Байгууллага, аж ахуй нэгж, иргэн нь хадлан бэлтгэхдээ хадуурын ирийг 10 см-ээс доош тавьж хадахгүй байх

5.3. Газрын хөрс, ургамлын бүтцэд сөрөг нөлөө үзүүлдэг тоног төхөөрөмж, саран тармуур ашиглахгүй байх

5.4. Хадлан бэлтгэх зориулалттай тоног төхөөрөмж, машин, техник хэрэгсэлд ариутгал халдвартгүйжүүлэлт хийлгэсний дараа талбайд ир тавих

**Зургаа. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүлээх үүрэг:**

6.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу талбайг эзэмшиж хамгаална.

6.2. Хадлан бэлтгэхээр авсан талбайгаа бусдад шилжүүлэхгүй байх

6.3. Хадлангийн газрыг үр ашигтай, зохицой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх

6.4. Хадлангийн газрын төлбөр болон байгалийн ургамал ашигласны төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх

6.5. Хадлан бэлтгэж дууссаны дараа талбайг өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх буюу нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлж талбайг тухайн сумын ЗДТГ-т хүлээлгэн өгөх

6.6. Газрын хөрсийг хамгаалах цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор олон салаа зам гаргахгүй байх, ахуйн хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлж цэвэрлэх.

6.7. Галын аюулгүй байдлын дүрмийг сахиж доорх шаардлагуудыг хангаж ажиллах, галын аюулаас урьдчилан сэргийлэх

а/ Хадлангийн салаа бүр галын аюулгүй байдлыг хангах үүднээс таваас доошгүй үлээгч аппарат болон ажиллаж буй хүний тоогоор цохиур троссон шүүр, хүрээ зэрэг багаж хэрэгслийг бэлтгэж ашиглахад бэлэн байлгах.

б/ Тээврийн хэрэгслэлийн гал унтраагуурыг стандартын дагуу бэлтгэх, өвс тээвэрлэх машин бүрт цохиур, троссон шүүр бэлтгэх, машин техникийн яндан оч баригчтай байх.

в/ Машин техник багаж хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангах, улсын үзлэг тооллого оношлогоонд орсон байх, галын аюултай бодис, шатах, тослох материалыг хэрэглэх, тээвэрлэх, хадгалах журам, горимыг чанд мөрдөж ажиллах.

г/ Хадлангийн салаа, бүлгийн ахлагч нь 14 хоног тутамд Онцгой байдлын газрын 7051101 утсанд мэдээлэл өгч ажиллах

д/ Гамшгийн хор уршгаас хүн амын эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, мал, амьтан, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулсан гэм буруутай албан байгууллага, аж ахуй нэгж, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

е/ Малын элдэв төрлийн гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс хадлангийн талбайд ашиглах техник, тоног төхөөрөмжинд мал эмнэлгийн мэргэжлийн байгууллагаар ариутгал халдвартгүйтгэл хийлгэж, маршрутын замаар тээвэр хийх

ё/ Хадлан бэлтгэж буй ажилчдад галын болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах сургалт зөвлөгөө өгч, гарын үсэг зуруулах

**Долоо. Хадлан бэлтгэх үйл ажиллагаанд тавих хяналт:**

- 7.1. Хадлангийн газар ашиглахтай холбоотой журмын хэрэгжилтэнд багийн ИНХ, аймаг, сумын ИТХ, бүх шатны засаг дарга, мэргэжлийн эрх бүхий байгууллагууд хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавина.
- 7.2. Гэрээт талбайгаас илүү гаргаж хадсан болон бусдад хадлангийн газар ашиглах эрхээ шилжүүлсэн тохиолдолд гэрээг цуцалж бэлтгэсэн өвс, тэжээлийг улсын орлого болгоно.
- 7.3. Уг журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг зөрчлийн шинж байдлаас шалтгаалж холбогдох хууль, журмын дагуу зохих хариуцлага ногдуулна.

**Найм. Хадлан бэлтгэхтэй холбогдон үүсэх маргааныг шийдвэрлэх:**

- 8.1. Хадлан бэлтгэхтэй холбогдон гарсан аливаа асуудлыг талууд хоорондоо харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 8.2. Энэ журамд зааснаар маргаан шийдвэрлэгдээгүй бол шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

-----oOo-----